



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/53

Мандалговь

Түгээмэл тархацтай ашигт малтмалын  
хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 1 сарын 24-ний өдрийн 05 тоот тогтоол, Ашигт малтмал газрын тосны газрын дүгнэлт, Өндөршил сумын ИТХ-ын саналыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Өндөршил сумын Хэц, Зээгийн хэц, Өлзийт нэртэй газруудад заасан хэмжээ, солбицолын дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хавсралтад заасан аж ахуйн нэгжүүдэд 3 жилийн хугацаагаар олгосугай.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг аж ахуйн нэгжүүдэд олгон, энэ тухай холбогдох төрийн байгууллагуудад мэдэгдэж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Өндөршил сумын Засаг дарга (Л.Мөнхбадрах) нарт үүрэг болгосугай.

Гурав. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлүүдэд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг болон байгаль орчныг хамгаалах үүргээ хэрэгжүүлж ажиллахыг "Мандал гео ресурс" ХХК-ний захирал (Ж.Дашхорол), "Эрдэс плазм" ХХК-ний захирал (А.Бадамдорж), "Хан богд лайм стон" ХХК-ний захирал (Л.Отгонбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010133

Аймгийн Засаг даргын 2019 оны 02 дүгээр сарын  
01 өдрийн 53 тоот захирамжийн хавсралт



ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН  
ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТАЛБАЙ

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Талбайн нэр	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ /га/
1	Өндөршил	"Эрдэс плазм" ХХК	Хэц	108° 20' 5"	45° 34' 0"	111.44
				108° 19' 10"	45° 34' 0"	
				108° 19' 10"	45° 34' 30.26"	
				108° 20' 5"	45° 34' 30.26"	
2	Өндөршил	"Хан богд лайм стоун" ХХК	Зээгийн хэц	108° 27' 52"	45° 33' 40"	200.4
				108° 28' 26"	45° 33' 40"	
				108° 28' 26"	45° 32' 12"	
				108° 27' 52"	45° 32' 12"	
3	Өндөршил	"Мандал гео ресурс" ХХК	Өлзийт	108° 23' 0.17"	45° 35' 45.45"	385.29
				108° 23' 0.17"	45° 34' 50.9"	
				108° 21' 32.34"	45° 34' 52.98"	
				108° 20' 52.08"	45° 35' 45.45"	